



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/141

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, 46.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 151 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Хувийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх ГААОНӨГ/202208091 дугаартай "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт 3700 тн нүүрс нийлүүлэх ажлыг "Ундрэм Оюу" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (А.Дэлгэржаргал)-т олгосугай.

2.Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (А.Дэлгэржаргал)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ